



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/117

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн ээлжит 05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр “Их эрсдэлтэй” үнэлэгдсэн, цас их орж зам даваа хаагдсаны улмаас өвөлжилтийн байдал хүндэрсэн, өвс тэжээлийн хомсдолд орсон байдлыг харгалзан Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газарт 5,000,000 (таван сая) төгрөгийн, Ханх сумын Засаг даргын Тамгын газарт 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Хөвсгөл нуурийн мөсний хөлдөлтийн байдлыг харгалзан Мөсөн замын тээврийн хяналт хийх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан Ханх сумын Засаг даргын Тамгын газарт 1,000.000 (нэг сая), Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газарт 1,000.000 (нэг сая), Хатгал тосгоны Захирагчийн ажлын албанд 500.000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
3. Дээрх зардлуудын нийт 8,700,000 (Найман сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.
4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН